



**МОНГОЛЫН  
БЭЛЧЭЭР АШИГЛАГЧДЫН  
НЭГДСЭН ХОЛБОО**

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАРТ**

Хаяг: Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбооны байр,  
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага Тойруу, 22-20А  
Утас: (+976) 9811 3747  
И-мэйл: info@greenmongolia.mn  
Веб хаяг: www.greenmongolia.mn

2020.9.9 № 79

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хариу санал хүргүүлэх тухай**

Газар Зохион Байгуулалт, Геодези, Зураг Зүйн Газраас Газар зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой Англи, Монгол нэр томъёоны тайлбарыг боловсруулахад Монголын Бэлчээр Ашиглагчдын Холбооноос санал өгөх хүсэлт гаргасны дагуу бидний зүгээс дараах үг хэллэгийг нэмж оруулах хүсэлтэй байгааг хүлээн авна уу.

№	Монгол	Англи	Тайлбар Монгол	Тайлбар Англи
1	Бэлчээр Ашиглагчдын Хэсэг	Pasture user groups	Дундын бэлчээрээ хамтран ашиглаж, үр шимийг нь хүртэж ирсэн, мал маллах арга ажиллагаа, нүүдэл суудлаа нутгийн онцлого, байгаль цаг уурын өөрчлөлт, даац чадавхид нь тохируулан уян хатан зохицуулах, доройтлоос хамгаалах, сэргээн сайжруулах нийтлэг ашиг сонирхол бүхий жилийн хэд хэдэн улиралд хамт нутагладаг, бие биенээ сайн мэдэх нэг нутаг усны малчин өрхүүдийн хамтын зохион байгуулалт	Pasture User Group (PUG) is a primary institution of herders self management at grassroots which plays a significant role in ensuring herders participation and voicing. While benefiting from the rangeland, PUG herders share common seasonal rangeland, know each other well and having common interest in using rangeland, animal husbandry, feature of movement environment and climate change, regulating rangeland based on carrying capacity, rangeland recover and protecting from degradation.

2	Монголын Бэлчээр Ашиглагчдын Нэгдсэн Холбоо	Mongolian National Federation of Pasture User Groups	Аймгийн бэлчээр ашиглагчдын холбоодын санаачлагын үндсэн дээр байгуулагдаж, тэдний эрх ашгийг дээдэлдэг, малчдын оролцоонд суурилсан бэлчээрийн менежментийг хөгжүүлэх, бэлчээр нутгаа хайрлан хамгаалах үйлсийг дэмждэг, гишүүнчлэлтэй, удирдах зөвлөл нь аймгийн бэлчээр ашиглагчдын холбоодын төлөөллөөс бүрддэг, байгууллага	The National Federation of Pasture User Groups (NFPUG) is established by initiatives from Aimag Federation of Pasture User Groups and representing the vital interests of them, supports the activities such as development of rangeland management based on herder's participation and protecting rangeland. NFPUG has a membership and steering committee consists of the representatives from Aimag Federation of Pasture User Groups
3	Аймгийн Бэлчээр Ашиглагчдын Холбоо	Aimag Federation of Pasture User Groups	Сумын бэлчээр ашиглагчдын холбоодын санаачлагын үндсэн дээр байгуулагдсан, тэдний эрх ашгийг дээдэлдэг, малчдын оролцоонд суурилсан бэлчээрийн менежментийг хөгжүүлэх, бэлчээр нутгаа хайрлан хамгаалах үйлсийг дэмждэг, гишүүнчлэлтэй, удирдах зөвлөл нь сумын бэлчээр ашиглагчдын холбоодын төлөөллөөс бүрддэг, байгууллага	Aimag Federation of Pasture User Groups (AFed) is established by the initiatives from Soum Association of Pasture User Groups, respecting their interest, supports the activities such as development of rangeland management based on herder's participation and protecting rangeland. AFed has a membership and steering committee consists of the representatives from Soum Association of Pasture User Groups
4	Сумын Бэлчээр Ашиглагчдын Холбоо	Soum Association of Pasture User Groups	Хамтын зохион байгуулалтад орсон малчдын санаачлагын үндсэн дээр байгуулагдаж, тэдний эрх ашгийг дээдэлдэг, малчдын оролцоонд суурилсан бэлчээрийн менежментийг хөгжүүлэх, бэлчээр нутгаа хайрлан хамгаалах үйлсийг дэмждэг, гишүүнчлэлтэй, удирдах зөвлөл нь бэлчээр ашиглагчдын хэсгийн төлөөллөөс бүрддэг, байгууллага	Soum Association of Pasture User Groups (APUG) is established by the initiatives from collective herders, respects their interest, develops rangeland management based on herder's participation, supports the activities such as development of rangeland management based on herder's participation and protecting rangeland. APUG has a membership and steering committee consists of the representatives from pasture user groups.
5	Бэлчээрийн менежмент	Rangeland management	Бэлчээр ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавихад чиглэсэн нутгийн захиргаа, малчдын хамтын ажиллагаа юм	Rangeland management is collective action of herders to properly use rangeland, plan, implement and monitor rangeland rehabilitation,

6	Экологийн чадавхийн тодорхойлолт	Ecological site description	Тухайн орчны хөрс, ус зүй, уур амьсгалын онцлогоос хамааран бэлчээрийн ургамлын төрөл, бүтээмж, ашиглалтыг тэсвэрлэх болон эргэн сэргэх чадавхи харилцан адилгүй бөгөөд хамтдаа бэлчээрийн экологийн чадавхийн тодорхойлолт болдог.	Ecological Sites description provides a consistent framework for classifying and describing rangeland and forestland soils and vegetation; thereby delineating land units that share similar capabilities to respond to management activities or disturbance.
7	Бэлчээрийн төлөв байдал	Rangeland health state	Бэлчээрийн ургамлын өсөлт хөгжил, экосистемд гүйцэтгэж буй үйл ажиллагааны цогц үнэлгээ	Comprehensive assessment of rangeland vegetation growth and ecosystem performance
8	Бэлчээр ашиглалтын гэрээ	Rangeland use agreement	Малчид хамтын зохион байгуулалтанд орж дундаа хувааж ашиглаж буй бэлчээрээ чанар, бүтээмжийг нь алдагдуулалгүй урт хугацаагаар ашиглах нөхцөлтэйгээр засаг даргатай байгуулдаг гэрээний баримт бичиг.	A contractual agreement with a governor that provides for long-term use of pastureland that herders have organized and shared without compromising their quality and productivity.
9	Бэлчээрийн даац	Rangeland carrying capacity	"Бэлчээрийн даац" гэж экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө учруулахгүйгээр тодорхой хугацаанд бэлчээх боломжтой мал, амьтны тоогоор илэрхийлэгдэх бэлчээрийн нэгж талбарын чадавхи	"Rangeland carrying capacity" means without adversely affecting the ecological balance rangeland expressed in terms of the number of animals that can graze for a certain period of time unit field capacity
10	Бэлчээрийн сэргэх чадавхи	Rangeland recovery	Бэлчээрийн ургамлын мал бэлчээрлэлт болон бусад ашиглалт, гадны хүчин зүйлийн нөлөөллийн дараахь сэргэн ургах чадавхи	Rangeland vegetation and other uses of livestock and their ability to regenerate after external influences
11	Бэлчээрийн сэргэх чадавхийн зарчим	Recovery class concept	Бэлчээрийн доройтлын түвшнээс хамааран сэргэх чадавхийн түвшин, хугацаа нь харилцан адилгүй байдаг тул сэргэх чадавхийн 5 түвшинд хуваагддаг.	The level and duration of recovery capacity varies depending on the level of rangeland degradation, so it is divided into 5 levels of recovery class.
12	Бэлчээрийн ачаалал	Stocking rate	"бэлчээрийн ачаалал" гэж тухайн улиралд бэлчээрийн нэгж талбарт бэлчин идээшилж байгаа хонин толгойд шилжүүлсэн малын тоог	"Rangeland load" means a number of animals for rangeland per unit area in a given season transferred to grazing sheep

13	Бэлчээрийн бүтээмж	Rangeland productivity	Бэлчээрийн ургамлын биомассын хэмжээ	Rangeland vegetation biomass
14	Бүлгэмдлийн шилжилт, өөрчлөлт	Community shifts	Байгаль цаг уур болон ашиглалт зэрэг гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр бэлчээрийн ургамлын бүтэц, зүйлийн бүрэлдэхүүн, голлох зүйл ургамлын арви өөрчлөгдсөнөөс бүлгэмдлийн шинэ хувилбарт шилжинэ.	Due to external factors such as climate and use, the structure of pasture plants, species composition, and abundance of key plant species will change to a new version.
15	Бэлчээрийн төлөв байдал, шилжилтийн загварууд	State and transition models	Ургамалжилтын төлөв байдлыг бүрдүүлэгч ургамлан бүлгэмдлүүд өөр хоорондоо шилжих цаашлаад нэг төлөв байдлаас нөгөө төлөв байдалд шилжих үйл явцыг үндсэн шалтгаан, болон ирээдүйд хүрч болох төлөв байдлыг диаграмм байдлаар үзүүлсэнийг “Бэлчээрийн төлөв байдал өөрчлөлтийн загвар” гэнэ.	The “Rangeland state transition model” is a model that shows the process of the transition of the plant communities that make up the vegetation state to each other and the transition from one state to another, as well as the possible future state.
16	Төлөв байдлын боломжит хувилбарууд	Alternative states	Байгаль цаг уур болон ашиглалт зэрэг гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр бэлчээрийн ургамал нэг төлөвөөс нөгөө төлөвт шилжих бөгөөд орчны хөрс, цаг уурын онцлог, ашиглалтын эрчим, доройтлын түвшнээс хамаарах шилжилтийн боломжит хувилбаруудтай.	Rangeland vegetation moves from one state to another under the influence of external factors such as climate and use, and there are possible transition options depending on the surrounding soil, climatic characteristics, intensity of use, and level of degradation.
17	Сэргэн ургах, уян хатан чанар	Resilience	Гадаад хүчин зүйлсийн улмаас сүйтгэгдсэн бүлгэмдэл анхны төлөв байдалдаа эргэн орох чадвар	The ability of a community damaged by external factors to return to its original state
18	Сэргэх чадавхид суурилсан ашиглалт	Resilience based management	Сэргэх чадавхид суурилсан менежмент нь даяарчлалын энэ эринд экосистемийн үйлчлэлийг тогтвортой байлгахад чиглэсэн шинжлэх ухаан, зохион байгуулалт, бодлого, засаглалын хувьд нэгдмэл ажиллагаа мөн. Үндсэн зорилго нь нийгэм экологийн тогтолцоог шинэлэг, зохистой горимд оруулахад оршино.	Resilience-based management is the approach that integrates science, management, policy, and governance in order to sustain ecosystem services in the face of global change with the goal to prevent a social-ecological system from moving toward undesirable configurations or regimes or to promote new, desirable regimes

19	Босго утга	Threshold	Нэг төлөв байдлаас нөгөөд шилжих босго утга	The threshold value for moving from one state to another
20	Сайжруулалт	Restoration	Доройтолд орсон бэлчээрийн экосистемийг сайжруулах зорилго бүхий ургамал, амьтны бүлгэмдлийг нөхөн сэргээх аливаа үйл ажиллагаа	Activities to rehabilitate degraded rangeland ecosystems to improve plant and animal communities
21	Үр нэмэрлэн тариалах	Overseeding	Доройтолд орсон бэлчээрийн экосистемийг сайжруулах зорилгоор олон наст ургамлын үрийн хольцыг хачирлан тариалах	Cultivation of perennial seed mixtures to improve degraded pasture ecosystems
22	Аж ахуйн бүлгүүд	Functional groups	Ургамлыг биологи морфологийн онцлог, экосистемд гүйцэтгэх үүргээр нь үетэн, алаг өвс, буурцагтан зэрэг аж ахуйн бүлэгт хуваадаг.	Plants are divided into groups of grasses, grasses, and legumes according to their biological and morphological characteristics and their role in ecosystems.
23	Идэмж	Palatability	Бэлчээрийн ургамлыг малд идэгдэх байдлаар нь бэлчээрийн ургамлыг идэмж сайтай, дунд зэргийн идэмжтэй, идэмж муутай хэмээн ангилдаг.	Pasture plants are classified as highly edible, moderately nutritious, and inedible by the way they are eaten by livestock.
24	Бэлчээрлэлтийн ачаалал	Grazing pressure	Мал бэлчээрлэлтээс бэлчээрт үзүүлэх дарамт, түүний хэмжээ нь бэлчээрлэж байгаа малын тоо нягтрал, бэлчээрлэлтийн үргэлжлэх хугацаанаас хамааран харилцан адилгүй	Rangeland pressure from pasture to pasture and its size varies depending on the number of grazing animals, density and duration of grazing
25	Доройтол	Degradation	Урт хугацаагаар даацаас хэтрүүлэн ашигласнаас бэлчээрийн ургамлын бүтэц, бүрэлдхүүн өөрчлөгдөж, унаган ургамлууд хөл газрын ургамлаар солигдож, бүтээмж нь буурах үйл явц	Prolonged overuse can lead to changes in the structure and composition of rangeland vegetation, the replacement of native vegetation with ground vegetation, and a decline in productivity
26	Талхлагдал	Overgrazing	Бэлчээрийн ургамлын бүлгэмдлийг нөхөн сэргэх чадавхиас нь илүү хурдацтайгаар ашиглах бэлчээрлэлт, идээшлэлтийн үйл явц бөгөөд ингэснээр бэлчээрийн чанар, бүтээгдхүүнд сөрөг үйлчлэл гарахад хүргэдэг	It is a process of grazing that uses pasture plant communities more rapidly than their regenerative capacity, which leads to adverse effects on rangeland quality and productivity.

27	Экологийн чадавхийн бүлгүүд	Ecological site groups	Тухайн орчны хөрс, ус зүй, уур амьсгалын онцлогоос хамаарсан бэлчээрийн ургамлын төрөл, бүтээмж, ашиглалтыг тэсвэрлэх болон эргэн сэргэх чадавхийн ялгаатай байдал дээр үндэслэн Монгол орны бэлчээрийг экологийн чадавхийн 22 бүлэгт хуваадаг.	Mongolia's pastures are divided into 22 groups of ecological capacity based on differences in the type, productivity, use, resilience and regenerative capacity of rangeland plants depending on the soil, hydrology and climate of the area.
28	Сэлгэж ашиглах	Rotational grazing	Бэлчээрийн доройтлоос сэргийлэхийн тулд бэлчээрийг сэлгэж ашиглах	Rotational grazing is grazing livestock to different sections of the rangeland for a certain period in order to maintain healthy, nutritious forages.
29	Нэг наст ургамал	Annuals	Соёолохоос эхлээд үрээ боловсруулах, вегетатив хэсэг нь үхэх хүртэлх өсөлт хөгжлийг ургамлын 1 л улиралд багтаан явуулдаг ургамлууд	Plants that develop from germination to seed processing and vegetative part to death within 1 year of growth season
30	Олон наст ургамал	Perennials	Хоёр эсвэл түүнээс дээш жил амьдардаг ургамал бөгөөд бие гүйцсэнээс хойш жил тутам цэцэглэж үрлэнэ.	It is a plant that lives for two or more years and blooms every year after maturing.
31	Бэлчээрийн төлөв байдлын мониторинг	Rangeland health monitoring	Бэлчээрийн ургамлын төлөв байдлын өөрчлөлт, хөдлөл зүйг урт болон богино хугацаанд хянах үйл ажиллагаа	Long-term and short-term monitoring of changes in rangeland vegetation status and mobility
32	Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ	Rangeland health assessment	Бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтийг анхны соргог, эсвэл зорилтот жилийн лавлагаа төлөв байдалтай харьцуулж үнэлэх үйл ажиллагаа	Assessment of changes in rangeland condition compared to the initial alert or target year reference status
33	Бэлчээрийн төлөв байдлын цэгэн зураглал	Dot map of rangeland health	Засаг захиргааны нэгж болон ашиглалтын хувилбарыг төлөөлөх бэлчээрийн мониторингийн үндэсний сүлжээний мониторингийн мэдээлэл дээр үндэслэсэн зураглал	Mapping based on national rangeland monitoring network data, which represents administrative units and use options
34	Хяналтын цэгүүд	Monitoring plot	Бэлчээрийн төлөв байдал, бүтээмжийн өөрчлөлт, ашиглалтын нөлөөг жил бүр тогтсон хугацаанд хянах зорилгоор байгуулсан Засаг захиргааны нэгж болон ашиглалтын хувилбарыг төлөөлөх байнгын цэгүүд	Permanent points representing administrative units and use options established to monitor rangeland condition, productivity changes, and impacts on a regular basis each year

35	Соргог төлөв байдал	Reference state	Бэлчээрийн ургамлын байгалийн унаган төлөв байдал	Natural state of rangeland vegetation
36	Өнгөн хөрсний үзүүлэлтүүд	Soil surface indicators	Мал бэлчээрлэлтээс бэлчээрийн ургамалд төдийгүй өнгөн хөрсөнд үзүүлж буй нөлөө, түүнээс үүдэлтэй элэгдэл эвдрэлийг тодорхойлох үзүүлэлтүүд	Impact of livestock grazing not only on rangeland plants but also on topsoil and indicators of erosion caused by it
37	Хөрсний тогтвортой байдал	Soil stability	Бэлчээрийн талхлагдлын улмаас өнгөн хөрсний бүтэц, чанар өөрчлөгдөж салхи, усны элэгдэлд мэдрэмтгий болдог. Энэхүү мэдрэмтгий байдлыг өнгөн хөрсний тогтвортой байдлыг тодорхойлох замаар тогтоодог.	Overgrazing changes the structure and quality of topsoil and makes it more sensitive to wind and water erosion. This sensitivity is determined by determining the stability of the topsoil.
38	Дэгнүүл үүсгэх	Pedestaling	Бэлчээрийн талхлагдлаас ургамлын үндсээрээ хөрсийг барьж тогтворжуулах чадвар буурч хөрс ус салхины элэгдэлд орсны улмаас ургамлын үндэсний систем нь ил гарах нөхцөл байдал	Conditions in which the root system of plants is exposed due to the overgrazing soil and water erosion the decrease of plant's hold and stability due to the overgrazing and soil and water erosion
39	Бэлчээрийн зохистой ашиглалт	Proper management of rangeland	"Бэлчээрийг зохистой ашиглах" гэж ашиглалтыг тухайн бэлчээрийн даац, төлөв байдал, сэргэх чадавхийн түвшинд тохируулан чанар, төлөв байдлыг дорйотуулахгүй ашиглахыг хэлнэ.	"Proper use of rangeland" means the use of pastureland in accordance with the level of carrying capacity, condition and regenerative capacity of the pastureland without degrading its quality and condition.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.ГАНХУЯГ